



**НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

Цаг бүртгэлийн төхөөрөмжийг
түр зогсоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусийн эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ныг дуустал байгууллагын нийт албан хаагчид цаг бүртгэлийн төхөөрөмжид хурууны хээг уншуулахыг түр зогсоосугай.

2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор албан хаагчдын ажилд ирэх, ажлаас тарах цагийн бүртгэлийг цаг, минутаар тооцож бүртгэхийг диспетчер-механикуудад даалгасугай.

3. Заагдсан хугацаанд диспетчер-механикуудын цаг бүртгэлд хяналт тавьж ажиллахыг Тээвэр, зохицуулалтын хэлтэс/ Х.Ажрахгүй/-т, ажиллаж байгаа албан хаагчдад тухайн өдрийн цалин, нэмэгдэл хөлсийг тооцож олгохыг Санхүү, төлөвлөлтийн хэлтэс/ Х.Одончимэг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.НАРАНБААТАР